

Үндэсний Статистикийн хорооны зөвшөөрснөөр Нийслэлийн Засаг даргын 2014 оны 7-р сарын 25-ны өдрийн А\633 тоот захирамжаар батлав.

Маягт ЭАБ-А

Дүүргийн ЗДТГ нь үнэлгээний хуудсыг хороо бүрээс авч нэгтгэн цахим хэлбэрээр НЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэст 12-р сарын 20-ны дотор хүргүүлнэ.

ТАМХИГҮЙ ОРЧИН БҮРДҮҮЛСЭН АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Регистрийн дугаар	Үнэлгээний шалгуур үзүүлэлт											
			Дотоод журам	Анхааруулга тэмдэг				Тамхины эсрэг мэдээлэл	Ажлын байрны дотоод орчинд тамхи татаж байгаа эсэх	Тамхины сурталчилгаа	Тамхи татдаг хүн байдаг эсэх	Байгууллагын гадаад орчинд тамхи татахгүй нөхцөл бүрдүүлсэн эсэх	Тамхигүй хамт олон болох хөдөлгөөн өрнүүлсэн эсэх	Шаардлага хангасан эсэх
				Орох хаалга	Хүлээлгийн танхим	Бие засах газар	Бусад газар							
	А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Үнэлгээ хийсэн багийн гишүүдийн нэр, гарын үсэг

Хянасан үнэлгээний багийн ахлагчийн нэр, гарын үсэг

20... оны р сарын өдөр

Тамхигүй орчин бүрдүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын үнэлгээний хуудсыг нөхөх заавар



Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь өөрийн нутаг дэвсгэрт байршиж, тухайн жилийн турш үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтаас санамсаргүй түүвэр хийж, тамхигүй орчин бүрдүүлсэн эсэх үнэлгээг сонгогдсон аж ахуйн нэгжид хийнэ. Санамсаргүй түүврийн хэмжээг дараахь байдлаар тооцно.

Багана А

Аж ахуйн нэгж, байгууллагын албан ёсны нэрийг бичнэ. Аж ахуйн нэгж, байгууллага гэдэг нь өөрийн нэрийн өмнөөс үйлдвэрлэл, үйлчилгээ тогтвортой эрхэлж, үйл ажиллагаатай холбогдон үүсэх үүргийг эд хөрөнгөөрөө хариуцаж байгаа этгээдийг аж ахуйн нэгж гэнэ. ААНБ нь улсын бүртгэлд бүртгүүлж, регистрийн дугаартай байна.

Багана Б Багана 1

Тухайн ААНБ-ын улсын бүртгэлийн гэрчилгээний регистрийн дугаарыг нөхөж бичнэ. ААНБ нь холбогдох хуульд заасны дагуу тамхины хяналтын үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг өөрийн хөдөлмөрийн дотоод журамд тусгаж, хэрэгжилтэд нь байнгын хяналт тавьдаг бол (1), үгүй бол (2) кодыг нөхнө.

Багана 2-5

ААНБ-ын орох хаалга, хүлээлгийн танхим, үйлчилгээний танхим болон хонгил, бие засах газар, бусад шаардлагатай газарт тамхи татахыг хориглосон анхааруулга тэмдгийг байрлуулсан бол (1), үгүй бол (2) кодыг нөхнө. Анхааруулга тэмдэг нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан загварын дагуу хийгдсэн байна.

Багана 6

Байгууллагын ажилтнуудыг тамхины хэрэглээ, дам тамхидалтын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд учрах эрсдэл, хор хөнөөлийн талаар шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллээр хангасан бол (1), үгүй бол (2) кодыг нөхнө.

Багана 7

ААНБ-ын орох хаалганы орчим болон ажлын байранд тамхины утаа үнэртэж буй эсэх, үнсний сав байгаа эсэх, хогийн саванд тамхины иш, үлдэгдэл байгаа эсэх зэрэг энгийн ажиглалтаар дотоод орчинд утаат тамхи татдаг эсэхийг тогтооно. Үгүй бол 1, тийм бол 2 кодыг нөхнө.

Багана 8

Тамхины ил, далд сурталчилгаа байхгүй бол (1), байвал (2) кодыг нөхнө.

Багана 9

ААНБ-ын нийт ажилтан тамхи татдаггүй бол (1) код, тамхи татдаг хүн байдаг бол (2) кодыг нөхнө.

Багана 10

ААНБ-ын гадна эргэн тойронд 10 метрээс дотогш хэсэгт "Тамхи татахгүй" анхааруулга тавьсан, хогийн саванд тамхины иш, үлдэгдэл байхгүй бол (1), "Тамхи татахгүй" анхааруулга тавиагүй, тамхины иш, үлдэгдэл байвал (2) кодыг нөхнө.

Багана 11

Тамхигүй хамт олон болох хөдөлгөөн өрнүүлсэн тухай тушаал шийдвэр гарч, хэрэгжүүлсэн бол (1) код, үгүй бол (2) кодыг нөхнө.

Багана 12

Үнэлгээний бүх шалгуур үзүүлэлтэд (1) гэсэн хариулт авсан ААНБ нь "Тамхигүй орчин бүрдүүлсэн ААНБ"-ын шаардлагыг хангасан гэж (1), аль нэг үзүүлэлтэд үгүй (2) кодыг нөхсөн эсвэл үнэлэх боломжгүй бол "Тамхигүй орчин бүрдүүлсэн ААНБ"-ын шаардлагыг хангаагүй гэж (2) кодыг бичнэ.

Хорооны нутаг дэвсгэрт байршиж үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын тоо	Үнэлгээ хийх ААНБ-ын тоо
10 хүртэл	бүх ААНБ
11-60	10
61-100	15
101- 150	20
151- 250	25
251- 300	30
301-400	35
401-520	40
521-600	50
601-750	60
751-1000	70
1000-аас дээш	100

Үнэлгээ хийх аж ахуйн нэгж, байгууллагын тоотой уялдуулж нэмэлт хуудсыг маягтын дагуу үргэлжүүлэн хийж нэгтгэнэ.